

Луус сумын 9 жилийн сургуульд багш, ажилтан сонгон шалгаруулж авах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Луус сумын 9 жилийн сургууль/цаашид сургууль гэх/-д ажилд орох багш, ажилтан, үйлчилгээний ажилчдыг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Багш, ажилтан, үйлчилгээний ажилчдыг сонгон шалгаруулах журам/ цаашид журам гэх/ нь Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Боловсролын ба бага дунд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.
- 1.3. Энэхүү журмын зорилго нь тус сургуулийн хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг чанаржуулахад оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

- 2.1. Сургуулийн захирал, захирлын дэргэдэх зөвлөлтэй хамтран тодорхой шалгуурын дагуу багш ажилтныг шалгаруулж ажилд авна.
- 2.2. Сургуулийн үндсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, урт хугацааны цалингүй чөлөө авах, хүүхэд асрах болон бусад нөхцөлөөр чөлөө авснаар гарсан сул орон тоо, мөн шинээр бий болсон орон тоонд авч ажиллуулах иргэнд тавигдах ерөнхий шаардлага нь сургуулийн захирлаар батлуулсан тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтоор тогтоогдоно.
- 2.3. Сонгон шалгаруулалтанд оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно. Нийтлэг шалгуурт тухайн шалгаруулалтанд оролцогчийн ерөнхий соёл, ёс зүйн зөрчилгүй байх, бүтээлч, өөрчлөлтийг манлайлах, харилцааны болон багаар ажиллах чадварыг үнэлж, тусгай шалгуурт мэргэжлийн арга зүй ур чадвар, багш бол багшлах эрхийн шалгуурыг ханган шалгалтанд тэнцсэн байх, туршлага, гадаад хэл, мэдээллийн технологийн чадварыг харж тодорхойлно.
- 2.4. Тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг ажлын хэсгийн хурлаар тухай бүр шийдвэрлэж, ажлын байрны зар, тавигдах шалгуур, сонгон шалгаруулах журам, шалгаруулалтын явц, дүнг байгууллагын цахим хуудас буюу dundgovi.gov.mn хаягаар ба 99599270, 90196561, 99464362 гэсэн дугааруудын утсаар олон нийтэд нээлттэй хүргэнэ.

Гурав. Оролцогчийн бүрдүүлэх материал

- 3.1. Сонгон шалгаруулалтанд оролцогчид дараах материалыг бүрдүүлнэ.
 - 3.1.1. Биеийн байцаалт/ Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу/
 - 3.1.2. 4х6 – ийн цээж зураг 2 хувь
 - 3.1.3. Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр наториатаар батлуулсан хуулбарын хамт
 - 3.1.4. Их дээд сургууль төгссөн диплом, хавсралт, багшлах эрхийн шалгалтанд тэнцсэн тухай үнэмлэх гэрчилгээг наториатаар батлуулсан хуулбарын хамт
 - 3.1.5. Ажиллаж байсан бол ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт, ажиллаж байсан байгууллагынхаа ажил байдлын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт
 3. 1.6. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг ур чадвараа илэрхийлсэн өргөдөл
 - 3.1.7. Мэргэжил дээшлүүлсэн байдлыг илэрхийлэх гэрчилгээ, сертификат хуулбарын хамт
 - 3.1.8. Шинээр орох ажилтан нь хөдөлмөрийн зах зээлд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайгч байна.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Сонгон шалгаруулалтын явцад гарсан аливаа санал, гомдол, маргаантай асуудлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж гомдол гаргагчид бичгээр мэдээлнэ.
- 4.2. Гомдол гаргагч ажлын хэсгийн шийдвэрийг эс зөвшөөрвөл сургуулийн захиралд хандаж болно.
- 4.3. Жич: Улирлын шинжтэй ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилчдыг 10 дугаар сарын 1-ээс 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд авч ажиллуулж гэрээ байгуулна.
- 4.4. Шаардлагатай мэргэжилтэнг тодорхой хугацаанд гэрээгээр авч ажиллуулна.